

“ГАН ЗАМ ДААТГАЛ” ХХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 07 дугаар сарын 28-ны
өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

Журам, заавар, дүрэм, бодлогын баримт
бичиг батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 145 дугаар тогтоолоор
батлагдсан “Компанийн засаглалын кодекс”-ийн 2.2, 2.3, 2.4-т заасан зарчим
болон “Ган зам даатгал” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 07
дугаар сарын 28-ны өдрийн хурлын тэмдэглэлийн 2.2-т заасныг үндэслэн
ТОГТООХ НЬ:

Нэг. “Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны журам”-ыг 1 дүгээр
хавсралтаар, “Аудитын бодлогын баримт бичиг”-ийг 2 дугаар хавсралтаар,
“Төлөөлөн удирдах зөвлөлийн Цалин, урамшууллын хорооны журам”-ыг 3
дугаар хавсралтаар, “Цалин, урамшууллын бодлогын баримт бичиг”-ийг 4
дүгээр хавсралтаар, “Төлөөлөн удирдах зөвлөлийн Нэр дэвшүүлэх хорооны
журам”-ыг 5 дугаар хавсралтаар, “Залгамж халааны бодлогын баримт бичиг”-
ийг 6 дугаар хавсралтаар, “Ёс зүйн дүрэм”-ийг 7 дугаар хавсралтаар,
“Мэдээллийн ил тод байдал, тайлагналын журам”-ыг 8 дугаар хавсралтаар,
“Эрсдэлийн удирдлагын заавар”-ыг 9 дүгээр хавсралтаар, “Комплайнсын
хяналтын заавар”-ыг 10 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Батлагдсан журам, заавар, дүрэм, бодлогын баримт бичгийг үйл
ажиллагаандaa мөрдөж ажиллахыг холбогдох Хороод, “Ган зам даатгал” ХХК-
ийн гүйцэтгэх захирал /В.Отгондэмбэрэл/-д үүрэг болгосугай.

Хурлын дарга

Н.Энхцогт

УЛААНБААТАР ХОТ
“Ган зам даатгал” ХХК-ийн Төлөөлөн удирдах
зөвлөлийн 2022 оны 07 дугаар сарын 28-ны
өдрийн хурлын 09 дүгээр Тогтоолын
01 дүгээр хавсралт

ХХК
1110020509 4 2010013

“Ган зам даатгал” ХХК-ийн Төлөөлөн удирдах
зөвлөлийн Аудитын хорооны журам

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь “Ган зам даатгал” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл/ТҮЗ-/ийн Аудитын хороо/Хороо/-ны бүрэлдэхүүн, түүний чиг үүрэг, үйл ажиллагааг тодорхойлоход оршино.

Хоёр. Хорооны бүрэлдэхүүн, дарга, гишүүнийг
сонгох, чөлөөлөх

- 2.1. Хорооны бүрэлдэхүүн нь дарга болон 2 /хоёр/ гишүүнээс бүрдэх бөгөөд ТҮЗ-ийн гишүүдээс сонгогдоно.
- 2.2. ТҮЗ-ийн хуралд оролцсон гишүүдийн дийлэнх олонхийн саналаар Хорооны дарга, гишүүнийг сонгож, чөлөөлнө.
- 2.3. Хорооны дарга нь “Компанийн тухай хууль”-ийн 81 дүгээр зүйлийн 81.4-т заасны дагуу ТҮЗ-ийн хараат бус гишүүн байна.
- 2.4. Хорооны гишүүнээр компанийн гүйцэтгэх захирал сонгогдохгүй.

Гурав. Хорооны чиг үүрэг

Хороо нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- 3.1. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар томилогдсон ТҮЗ-ийн аудитороор дамжуулан компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэгжилт, нягтлан бодох бүртгэлийг олон улсын стандартын дагуу явуулж буй эсэхэд хяналт тавих;
- 3.2. Мөн дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, даатгалын мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих;
- 3.3. Компанийн жилийн эцсийн даатгал, санхүүгийн үйл ажиллагаанд ТҮЗ-ийн аудиторын хийсэн шалгалтын дүгнэлттэй танилцаж, ТҮЗ-ийн хуралд оруулах;
- 3.4. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар томилогдсон хөндлөнгийн аудиторыг чиг үүргээ саадгүй хэрэгжүүлэх нөхцөл боломжоор компанийн зүгээс хангуулах;

- 3.5. Хороо чиг үүргийнхээ хүрээнд шаардлагатай бичиг баримт, тайлан, мэдээллийг компанийн эрх бүхий албан тушаалтан, ажилтнаас гаргуулан авч, дүгнэлт гаргаж, ТҮЗ-д танилцуулах;
- 3.6. Компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсанд аудитын бодлого, Хорооны бүрэлдэхүүн, үйл ажиллагааны журам, хурлын талаар нийтэд мэдээлэх.
- 3.7. Хороо компанийн эрсдэлийн удирдлагын асуудлыг давхар хариуцна.

Дөрөв. Хорооны үйл ажиллагаа

- 4.1. Хорооны үйл ажиллагаа явуулах үндсэн хэлбэр нь Хорооны хурал байна.
- 4.2. Хорооны хурлыг Хорооны дарга, Хорооны гишүүдийн олонхийн санал болгосноор, эсхүл ТҮЗ-ийн даргын шийдвэрээр хуралдуулна.
- 4.3. Хорооны хурлыг видео болон аудио, эчнээгээр хийж болно.
- 4.4. Хурлыг Хорооны дарга, түүний эзгүйд түүний даалгаснаар Хорооны аль нэг гишүүн удирдан явуулна.
- 4.5. Хорооны гишүүдийн дийлэнх олонх оролцсоноор хурлын ирц бүрдсэн гэж үзнэ.
- 4.6. Хорооны хурлын нарийн бичгийн даргын үүргийг ТҮЗ-ийн нарийн бичгийн дарга гүйцэтгэнэ.
- 4.7. Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 145 дугаар тогтоолоор батлагдсан "Компанийн засаглалын кодекс"-ийн 2.2-т заасны дагуу гүйцэтгэх захирал, ажилтнууд гагцхүү Хорооны хүсэлтээр хуралд оролцено.
- 4.8. Хурлын хэлэлцэх асуудал, мэдээллийг хорооны гишүүдэд утсаар, цахимаар, цахим шуудангаар хүргэж болно.
- 4.9. Хэлэлцэж байгаа асуудлын талаар гишүүдийн гаргасан санал, дүгнэлтийг хурал даргалагч нэгтгэн гишүүдийн санал хурааж, олонхийн саналаар шийдвэрлэж, хурлын тэмдэглэлд тусгана.
- 4.10. Хурлын тэмдэглэлд хуралд оролцсон гишүүд гарын үсэг зурж, баталгаажуулна.



“Ган зам даатгал” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн хурлын 09 дүгээр Тогтоолын 02 дугаар хавсралт

“Ган зам даатгал” ХХК-ийн Аудитын бодлогын баримт бичиг

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартын дагуу явуулах, дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, даатгалын үйл ажиллагааны мэдээллийн үнэн бодит байдлыг ханган ажиллахад аудитын бодлогын зорилго чиглэгдэнэ.

Хоёр. Үндсэн чиглэл

- 2.1. Аудитын бодлого нь компанийн даатгал, санхүүгийн үйл ажиллагааг үнэлэх, сайжруулах, түүний үнэ цэнийг нэмэгдүүлэхээр хараат бус, бие даасан бодитойгоор баталгаа өгөх, зөвлөхөд чиглэгдэнэ. Үнд:
 - 2.1.1. Компанийн засаглалын үйл явцыг үнэлэх, сайжруулах зөвлөмж өгөх;
 - 2.1.2. Эрсдэлийн удирдлагын талаар дүгнэлт хийх;
 - 2.1.3. Дотоод хяналтын байдалд үнэлгээ хийх, зөвлөмж өгөх, дэмжлэг үзүүлэх;
 - 2.1.4. Компанийн санхүүгийн үйл ажиллагаа нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн, мөрдөж буй заавар, журмын дагуу үнэн зөв явж, тайлагнаж буйд аудитын дүгнэлт хийх, зөвлөмж өгөх.

Гурав. Зарчим

- 3.1. Аудитын бодлогод дараах зарчмуудыг баримтална. Үнд:
 - 3.1.1. Шударга байх;
 - 3.1.2. Мэргэжлийн байх, мэдлэг, ур чадвартай байх;
 - 3.1.3. Хараат бус, бие даасан байх;
 - 3.1.4. Үнэн зөв мэдээлэлд үндэслэж, бодитой хандах;
 - 3.1.5. Зохисгүй нөлөөллөөс ангид байх;
 - 3.1.6. Компанийн стратеги, зорилтдоо хүрэхэд дэмжлэг үзүүлэх, учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлох;

3.1.7. Шинийг эрэлхийлсэн, санаачлагатай, ирээдүйг харсан байх;

3.1.8. Компанийн үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн байх.

Дөрөв. Компанийн үүрэг

4.1. Аудитын бодлогын хэрэгжилтэд компани дараах үүрэг хүлээнэ.
Үүнд:

4.1.1. Аудитын үйл ажиллагаанд хараат бусаар ажиллах нөхцөл боломжоор хангаж, ямарваа нэгэн хүндрэл учруулахгүй байх;

4.2.2. Аудитын үйл ажиллагаанд шаардагдах баримт, материал, лавлагаа, мэдээ, тайлбарыг хугацаанд нь гаргаж өгөх;

4.3.3. Шаардлагатай тохиолдолд ярилцлага, санал, асуулгад оролцох;

4.3.4. Аудитын үйл ажиллагааны дүнтэй танилцаж, өгсөн зөвлөмж, даалгаврыг хэрэгжүүлж ажиллах.

Тав. Аудитын хороо


5.1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/ Аудитын хороог байгуулж, дарга, гишүүдийг сонгоно.

5.2. Аудитын хороо ТУЗ-ийн баталсан “Аудитын хорооны журам”-ыг мөрдөнө.

5.2. Аудитын хороо “Аудитын бодлогын баримт бичиг”-ийг ТУЗ-д оруулан батлуулна.

5.3. “Аудитын бодлогын баримт бичиг”-т нэмэлт, өөрчлөлт оруулах бол Аудитын хороо саналаа ТУЗ-д оруулж, нэмэлт, өөрчлөлтийг шийдвэрлүүлж, батлуулна.

5.4. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар томилогдсон ТУЗ-ийн аудиторын хийсэн аудитын дүгнэлттэй Аудитын хороо танилцаж, ТУЗ-д оруулна.



“Ган зам даатгал” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн хурлын 09 дүгээр Тогтоолын 03 дугаар хавсралт

“Ган зам даатгал” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Цалин, урамшууллын хорооны журам

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь “Ган зам даатгал” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл/ТҮЗ/-ийн Цалин, урамшууллын хороо/Хороо/-ны бүрэлдэхүүн, түүний чиг үүрэг, үйл ажиллагааг тодорхойлоход оршино.

Хоёр. Хорооны бүрэлдэхүүн, дарга, гишүүнийг сонгох, чөлөөлөх

- 2.1. Хорооны бүрэлдэхүүн нь дарга болон 2 /хоёр/ гишүүнээс бүрдэх бөгөөд ТҮЗ-ийн гишүүдээс сонгогдоно.
- 2.2. ТҮЗ-ийн хуралд оролцсон гишүүдийн дийлэнх олонхийн саналаар Хорооны дарга, гишүүнийг сонгож, чөлөөлнө.
- 2.3. Хорооны дарга нь Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 145 дугаар тогтоолоор батлагдсан “Компанийн засаглалын кодекс”-ийн 2.3-т заасны дагуу ТҮЗ-ийн хараат бус гишүүн байна.
- 2.4. Хорооны гишүүнээр компанийн гүйцэтгэх захирал сонгогдохгүй.

Гурав. Хорооны чиг үүрэг

Хороо нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- 3.1. Компанийн боловсруулсан цалин, урамшууллын бодлогын баримт бичгийн төсөлд санал өгөх;
- 3.2. Компанийн цалин, урамшууллын бодлогын баримт бичгийг ТҮЗ-өөр батлуулах, хэрэгжилтэд нь хяналт тавих;
- 3.3. Компанийн даатгал, санхүүгийн хагас, бүтэн жилийн үр дүнгээр компанийн ажилтнууд болон удирдлага, Хувьцаа эзэмшигчдийн хурал /ХЭХ/, ТҮЗ-ийн дарга, гишүүдэд үр дүнгийн урамшуулал олгох санал боловсруулах, хэмжээг тогтоох, ХЭХ-аар батлуулах;
- 3.4. Хороо нь компанийн гүйцэтгэх захиралд олгох цалингийн дээд хязгаарыг тогтоож, тогтоосон хэмжээнд багтаан олгох саналыг ТҮЗ-д оруулах;
- 3.5. Хороо нь компанийн цалин, урамшууллын бодлого, түвшин тухайн цаг үеийн нэхцэл байдалд хэр нийцэж буй байдалд дүгнэлт хийж,

- шаардлагатай гэж үзвэл, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг ТҮЗ-ийн хуралд оруулж, шийдвэрлүүлэх;
- 3.6. Хороо чиг үүргийнхээ хүрээнд шаардлагатай бичиг баримт, тайлан, мэдээллийг компанийн эрх бүхий албан тушаалтан, ажилтнаас гаргуулан авч, дүгнэлт гаргаж, ТҮЗ-д танилцуулах;
 - 3.7. Компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсанд цалин, урамшууллын бодлого, Хорооны бүрэлдэхүүн, үйл ажиллагааны журам, хурлын талаар нийтэд мэдээлэх.

Дөрөв. Хорооны үйл ажиллагаа

- 4.1. Хорооны үйл ажиллагаа явуулах үндсэн хэлбэр нь Хорооны хурал байна.
- 4.2. Хорооны хурлыг Хорооны дарга, Хорооны гишүүдийн олонхийн санал болгосноор, эсхүл ТҮЗ-ийн даргын шийдвэрээр хуралдуулна.
- 4.3. Хорооны хурлыг видео болон аудио, эчнээгээр хийж болно.
- 4.4. Хурлыг Хорооны дарга, түүний эзгүйд түүний даалгаснаар Хорооны аль нэг гишүүн удирдан явуулна.
- 4.5. Хорооны гишүүдийн дийлэнх олонх оролцсоноор хурлын ирц бүрдсэн гэж үзнэ.
- 4.6. Хорооны хурлын нарийн бичгийн даргын үүргийг ТҮЗ-ийн нарийн бичгийн дарга гүйцэтгэнэ.
- 4.7. Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 145 дугаар тогтоолоор батлагдсан “Компанийн засаглалын кодекс”-ийн 2.3-т заасны дагуу гүйцэтгэх захирал гагцхүү Хорооны хүсэлтээр хуралд оролцено.
- 4.8. Хурлын хэлэлцэх асуудал, мэдээллийг хорооны гишүүдэд утсаар, цахимаар, цахим шуудангаар хүргэж болно.
- 4.9. Хэлэлцэж байгаа асуудлын талаар гишүүдийн гаргасан санал, дүгнэлтийг хурал даргалагч нэгтгэн гишүүдийн санал хурааж, олонхийн саналаар шийдвэрлэж, хурлын тэмдэглэлд тусгана.
- 4.10. Хурлын тэмдэглэлд хуралд оролцсон гишүүд гарын үсэг зурж, баталгаажуулна.

“Ган зам даатгал” ХХК-ийн Төлөөлөн удирдах
зөвлөлийн 2022 оны 07 дугаар сарын 28-ны
өдрийн хурлын 09 дүгээр Тогтоолын
04 дүгээр хавсралт

ХХК
1116220009 2010913


“Ган зам даатгал” ХХК-ийн Цалин, урамшууллын
бодлогын баримт бичиг

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү баримт бичгийн зорилго нь “Ган зам даатгал” ХХК-ийн цалин, урамшууллын бодлогын үндсэн зарчим, хэрэгжүүлэх арга, хэлбэр, чиглэлийг тодорхойлоход оршино.

Хоёр. Бодлогын чиглэл, зарчим

- 2.1. “Ган зам даатгал” ХХК-ийн цалин, урамшууллын бодлого нь ажилтнуудыг тогтвортой суурьшилтай, бүтээл өндөртэй, үр дунтэй ажиллуулах, тэдний идэвхи санаачлага, зүтгэлийг үнэлэх, урмыг сэргээхэд чиглэгдэнэ.
- 2.2. Ажилтнуудын цалинг тэдний ажил үүргийн хуваарь, ур чадвар болон үр дүнд суурилан тогтоож, олгоно.
- 2.3. Ажиллагсадын ажил үүргийн хуваарьт заасан ижил үүрэг, хөдөлмөрт адил цалин олгох бодлого баримтлана.
- 2.4. Ажилтнуудын цалин, урамшуулал тогтоох, олгоход аливаа ялгavarлал, гадуурхал, тэгш бус байдал гаргахгүй байх зарчим мөрдөнө.
- 2.5. Улсын хэмжээний дундаж цалингийн өсөлт болон “Улаанбаатар төмөр зам”-ын цалингийн өсөлттэй уялдуулан компанийн ажиллагсадын цалинг нэмэгдүүлж байх бодлого хэрэгжүүлнэ.
- 2.6. Үнийн өсөлт, инфляцийн түвшинтэй уялдуулан бодит цалингийн өсөлтийг хангах арга хэмжээг шаардлагатай үед авч хэрэгжүүлнэ.
- 2.7. Ажилтанд тасралтгүй удаан жил ажилласны нэмэгдлийг тус компанийд мөрдөгдөж буй журмын дагуу олгоно.
- 2.8. Ажилтанд ажилласан өдөрт нь унааны болон өдрийн хоолны хөнгөлөлтийг тогтоосон хэмжээгээр эдлүүлнэ.
- 2.9. ТҮЗ-ийн баталсан ““Ган зам даатгал” ХХК-ийн үр дүнгийн урамшуулал, түүнийг олгох журам”-ын дагуу компанийн даатгал, санхүүгийн хагас, бүтэн жилийн үр дүнгээр компанийн ажилтнууд болон удирдлага, ХЭХ, ТҮЗ-ийн дарга, гишүүдэд үр дүнгийн урамшууллыг жилд хоёр удаа олгоно.



“Ган зам даатгал” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн хурлын 09 дүгээр Тогтоолын 05 дугаар хавсралт

“Ган зам даатгал” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
Нэр дэвшүүлэх хорооны журам

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь “Ган зам даатгал” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл/ТҮЗ/-ийн Нэр дэвшүүлэх хороо/Хороо/-ны бүрэлдэхүүн, чиг үүрэг, үйл ажиллагааг тодорхойлоход оршино.

Хоёр. Хорооны бүрэлдэхүүн, дарга, гишүүнийг сонгох, чөлөөлөх

- 2.1. Хорооны бүрэлдэхүүн нь дарга болон 2 /хоёр/ гишүүнээс бүрдэх бөгөөд ТҮЗ-ийн гишүүдээс сонгогдоно.
- 2.2. ТҮЗ-ийн хуралд оролцсон гишүүдийн дийлэнх олонхийн саналаар Хорооны дарга, гишүүнийг сонгож, чөлөөлнө.
- 2.3. Хорооны дарга нь Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 145 дугаар тогтоолоор батлагдсан “Компанийн засаглалын кодекс”-ийн 2.4-т заасны дагуу ТҮЗ-ийн хараат бус гишүүн байна.

Гурав. Хорооны чиг үүрэг


Хороо нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- 3.1. ТҮЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчийн ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлагын талаарх мэдээлэл авч, шаардлага хангаж байгаа эсэхэд үнэлэлт өгөх, ТҮЗ-ийн хуралд оруулах;
- 3.2. ТҮЗ-ийн дэргэдэх Хороодын бүтэц, бүрэлдэхүүний талаар саналаа ТҮЗ-д танилцуулах;
- 3.3. ТҮЗ-ийн дэргэдэх Хороодын дарга, гишүүдэд нэр дэвшүүлж, ТҮЗ-д танилцуулах;
- 3.4. ТҮЗ-ийн хараат бус гишүүний хувьд Хороо нь “Компанийн тухай хууль”-ийн 79 дугаар зүйлийн 79.1-д заасан шалгуурыг хангасан хүний нэрийг дэвшүүлэх;
- 3.5. Хороо чиг үүргийнхээ хүрээнд шаардлагатай бичиг баримт, тайлан, мэдээллийг компанийн эрх бүхий албан тушаалтан, ажилтнаас гаргуулан авч, дүгнэлт гаргаж, ТҮЗ-д танилцуулах;

- 3.6. Компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсанд залгамж халааны бодлого, Хорооны үйл ажиллагааны журам, хурлын талаар нийтэд мэдээлэх.

Дөрөв. Хорооны үйл ажиллагаа

- 4.1. Хорооны үйл ажиллагаа явуулах үндсэн хэлбэр нь Хорооны хурал байна.
- 4.2. Хорооны хурлыг Хорооны дарга, Хорооны гишүүдийн олонхийн санал болгосноор, эсхүл ТҮЗ-ийн даргын шийдвэрээр хуралдуулна.
- 4.3. Хорооны хурлыг видео болон аудио, эчнээгээр хийж болно.
- 4.4. Хурлыг Хорооны дарга, түүний эзгүйд түүний даалгаснаар Хорооны аль нэг гишүүн удирдан явуулна.
- 4.5. Хорооны гишүүдийн дийлэнх олонх оролцсоноор хурлын ирц бүрдсэн гэж үзнэ.
- 4.6. Хорооны хурлын нарийн бичгийн даргын үүргийг ТҮЗ-ийн нарийн бичгийн дарга гүйцэтгэнэ.
- 4.7. Хурлын хэлэлцэх асуудал, мэдээллийг хорооны гишүүдэд утсаар, цахимаар, цахим шуудангаар хүргэж болно.
- 4.8. Хэлэлцэж байгаа асуудлын талаар гишүүдийн гаргасан санал, дүгнэлтийг хурал даргалагч нэгтгэн гишүүдийн санал хурааж, олонхийн саналаар шийдвэрлэж, хурлын тэмдэглэлд тусгана.
- 4.9. Хурлын тэмдэглэлд хуралд оролцсон гишүүд гарын үсэг зурж, баталгаажуулна.



“Ган зам даатгал” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн хурлын 09 дүгээр Тогтоолын 06 дугаар хавсралт

“Ган зам даатгал” ХХК-ийн Залгамж халааны бодлогын баримт бичиг

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Компани өөрийн даатгалын үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулж, өмнөө тавьсан зорилтоо амжилттай, үр дүнтэй биелүүлэхэд даатгалын ажлын мэдлэг, ур чадварыг эзэмшсэн, туршлага бүхий одоо бүрдсэн мэргэжилтэй боловсон хүчнийг тогтвортой суурьшилтай ажиллах нөхцөл, ажлын байран дээр өсөж дэвших боломжоор хангах бодлого баримтлана.

Хоёр. Залгамж халааны бодлогод тавигдах шалгуур

- 2.1. Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 179 дүгээр тогтоолоор батлагдсан “Банкнаас бусад санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх тохиромжтой этгээдийг тодорхойлох журам”-ыг удирдлага болгон Залгамж халааны бодлогод мэдлэг боловсрол, ажлын туршлага, гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчил, ёс зүй, нэр хүндийн шалгууруудыг баримтлана.

Гурав. Шалгүүр хангах үзүүлэлтүүд


- 3.1. Мэдлэг боловсрол, ажлын туршлагатай байх шалгуурыг дараах үзүүлэлтээр тодорхойлно:
 - 3.1.1. ТҮЗ, гүйцэтгэх удирдлага зэрэг эрх бүхий албан тушаалд банк, санхүү, нягтлан бодох бүртгэл, эдийн засаг, хууль, эрх зүйн чиглэлээр их дээд сургууль төгссөн байх;
 - 3.1.2. Тухайн албан тушаалд дүйцэхүйц албан тушаалд нэгээс доошгүй жил ажилласан туршлагатай байх;
 - 3.1.3. Санхүүгийн салбарт хоёроос доошгүй жил ажилласан байх.
 - 3.2. Гэмт хэрэгт холбогдож байгаагүй байх шалгуурыг дараах үзүүлэлтээр тодорхойлно:
 - 3.2.1. Эрүүгийн хуульд заасан болон мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, авилга, хээл хахууль, эдийн засгийн гэмт хэрэг, зөрчилтэй холбоотойгоор эрүүгийн хариуцлага, шийтгэл хүлээгээгүй байх;
 - 3.2.2. Эрүүгийн хуульд заасан болон мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, авилга, хээл хахууль, эдийн засгийн гэмт хэрэг, зөрчилтэй холбогдон

шалгагдах болон шүүх хуралд шүүгдэгчээр, хэрэг бүртгэл, мөрдөн байцаалтын шатанд сэжиглэгдэж байгаа эсэх.

- 3.3. Ёс зүйн нэр хүндтэй байх шалгуурыг дараах үзүүлэлтээр тодорхойлно:
- 3.3.1. Сүүлийн нэг жилийн хугацаанд өөрийн буруутай үйлдлээс, салбарын ёс зүйн хэм хэмжээг зөрчсөнөөс үүдэн ажлаас халагдах арга хэмжээ авахуулаагүй байх;
 - 3.3.2. Санхүүгийн болон санхүүгийн бус үйлчилгээ, үйл ажиллагаатай холбоотой үүссэн гомдлын гол буруутан байсан эсэх;
 - 3.3.3. Сүүлийн нэг жилийн хугацаанд салбарын ёс зүйн хэм хэмжээг зөрчөөгүй байх;
 - 3.3.4. Монгол улсын болон гадаад улсын нутаг дэвсгэрт хууль, журам, бизнесийн ёс зүй, дүрмийг зөрчсөн эсэх, бусдад энэхүү үйлдлийг хийхэд тусалсан хэрэгт холбогдоогүй байх;
 - 3.3.5. Монгол улсын болон гадаад улсын нутаг дэвсгэрт зохицуулалтын аливаа шаардлагыг хангахад, эсхүл мэргэжлийн болон ёс зүйн аливаа стандартыг дагаж мөрдөхөд бэлэн байх.
- 3.4. Ашиг сонирхлын зөрчлөөс анgid байх шалгуурыг дараах үзүүлэлтээр тодорхойлно:
- 3.4.1. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 21, 22 дугаар зүйлд харшлаагүй байх;
 - 3.4.2. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 3.1-д заасан санхүүгийн үйлчилгээнд хамаарах үйл ажиллагааг зохицуулсан тусгайлсан хуульд харшлахгүй байх.

Дөрөв. Шалгуур үзүүлэлтийн нотолгоо

- 4.1. Дээрх шалгуур, үзүүлэлтуудийг хангаж буй эсэх нотлох баримт нь төрийн болон хууль хяналтын байгууллага, мэргэжлийн холбоо, бусад холбогдох байгууллагуудын лавлагаа, мэдээлэл, тодорхойлолт, гадаад, дотоодын их дээд сургуулийн дипломын хулбар байна.



“Ган зам даатгал” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн хурлын 09 дүгээр Тогтоолын 07 дугаар хавсралт

“Ган зам даатгал” ХХК-ийн ёс зүйн
дүрэм

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү ёс зүйн дүрмийн зорилго нь компанийн ажилтан, эрх бүхий албан тушаалтан үйл ажиллагаанд баримтлах зарчим, мөрдөх ёс зүйн хэм хэмжээг тодорхойлоход оршино.

Хоёр. Компанийн ажилтны ёс зүйн
хэм хэмжээ

- 2.1. Компанийн ажилтан нь холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журам болон ёс зүйн дүрмийг чанд мөрдөн ажиллах;
- 2.2. Ажил, үүргээ шударга, ил тод, нээлттэй байдлаар явуулах, компанийн нэр хүндийг дээдлэх;
- 2.3. Хувьцаа эзэмшигч, харилцагч, даатгуулагч, бусад ажилтан зэрэг талуудын эрх ашгийг хүндэтгэх;
- 2.4. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг эрхэмлэх;
- 2.5. Өөрийн мэдлэг, ур чадвараа дээшлүүлж, ажил үүргээ мэргэжлийн түвшинд үнэнч шударгаар хариуцлагатай гүйцэтгэх;
- 2.6. Харилцан итгэлцэл, хүндлэл бүхий хамтын ажиллагааг эрхэмлэх;
- 2.7. Компанийн нэр хүнд, өмч хөрөнгийг хамгаалах;
- 2.8. Байгууллагын нууц болон үйл ажиллагааныхаа дагуу олж мэдсэн хувь хүний нууцыг холбогдох хуульд заасны дагуу хамгаалах;
- 2.9. Авилга, албан тушаалын гэмт хэргээс ангид байх;
- 2.10. Аливаа улс төрийн үйл ажиллагаанаас ангид байх.

Гурав. Төлөөлөн удирдах зөвлөлийн ёс зүйн
хэм хэмжээ

- 3.1. Холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журам болон ёс зүйн дүрмийг чанд мөрдөх;

- 3.2. Хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хангах;
- 3.3. Компанийн аливаа шийдвэр, үйл ажиллагаанд хувийн сонирхлоор хандахгүй, албан тушаалын давуу байдал үүсгэхгүй байх;
- 3.4. Дотоод мэдээллийг хууль бусаар ашиглахгүй, задруулахгүй байх;
- 3.5. Аливаа асуудалд үндэслэлтэй, шударга хандах;
- 3.6. Бусдад хүндлэлтэй хандах;
- 3.7. Авилга, албан тушаалын гэмт хэргээс ангид байх;
- 3.8. Аливаа улс төрийн үйл ажиллагаанаас ангид байх;

**Дөрөв. Гүйцэтгэх удирдлагын ёс зүйн хэм
хэмжээ**

- 4.1. Холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журам болон ёс зүйн дүрмийг чанд мөрдөх;
- 4.2. Үйл ажиллагаагаа шударга, ил тод, нээлттэй байдлаар явуулах;
- 4.3. Хувьцаа эзэмшигч, харилцагч, даатгуулагч, бусад ажилтан зэрэг талуудын эрх ашгийг хүндэтгэх;
- 4.4. Ажилтны саналыг сонсож, харилцан уялдаа бүхий эргэх холбоотой ажиллах;
- 4.5. Компанийн нэрийн өмнөөс оролцогчидтой харилцахдаа ёс зүйн хэм хэмжээг чанд сахих;
- 4.6. Албан үүргээ гүйцэтгэхдээ хамт олонтойгоо эелдэг, тэгш, хүлээцтэй, хүндэтгэлтэй хандах;
- 4.7. Авилга, албан тушаалын гэмт хэргээс ангид байх;
- 4.8. Аливаа улс төрийн үйл ажиллагаанаас ангид байх;
- 4.9. Энэ дүрмийг зөрчсөн аливаа үйлдэлтэй эс эвлэрч, өөрийн болон бусдын алдаа, дутагдлыг илрүүлэн засаж, ажиллах.

**Тав. Ашиг сонирхлын зөрчил, авлигаас сэргийлэх
талаар**

Компанийн эрх бүхий албан тушаалтан, ажилтан дараах ашиг сонирхлын зөрчил, авлигаас сэргийлж, ангид байна:


- 5.1. Чиг үүргээ хэрэгжүүлэхдээ өөртөө болон нэгдмэл сонирхолтой этгээдэд шууд болон шууд бусаар давуу тал олгох;

- 5.2. Оролцогч этгээдтэй үгсэн тохирох, амлалт өгөх, хахууль, шан харамж, хөнгөлөлттэй үйлчилгээ, зээл авах, хууль бусад хангамж эдлэх;
- 5.3. Хувь хүн, албан байгууллагаас зөвшөөрөгдсөнөөс бусад бэлэг хүлээн авах.

Зургаа. Хариуцлага

- 6.1. Ажилтан ёс зүйн дүрэм зөрчсөн тохиолдолд хохирлын хэмжээг харгалзан гүйцэтгэх захирлын тушаалаар түүнд "Хөдөлмөрийн дотоод журам"-д заасан сахилгын шийтгэл оногдуулна.
- 6.2. Гүйцэтгэх удирдлага, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнтэй холбоотой ёс зүйн зөрчлийг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэж, холбогдох шийтгэлийг оногдуулна. Шаардлагатай тохиолдолд Хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж, шийдвэрлүүлнэ.
- 6.3. Ёс зүйн дүрэм зөрчиж, зөрчил гаргасан нь гэмт хэргийн шинжтэй бол холбогдох хууль хяналтын байгууллагад шилжүүлнэ.
- 6.4. Ёс зүйн дүрэм зөрчиж, зөрчил гаргаж, шийтгэл хүлээсэн өдрөөс хойш нэг жилийн хугацаанд зөрчилтэйд тооцно.

-00-



“Ган зам даатгал” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн хурлын 09 дүгээр Тогтоолын 08 дугаар хавсралт

“Ган зам даатгал” ХХК-ийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журам

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Компани холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журамд заасны дагуу өөрийн санхүүгийн болон санхүүгийн бус мэдээллийг олон нийтэд нээлттэй тайлагнаж, мэдээлэх, ил тод байдлыг хангаж ажиллахад энэхүү журмыг мөрднө.

Хоёр. Мэдээллийн үйл ажиллагааны зарчим

- 2.1. Мэдээлэх, тайлагнах үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтлана:
 - 2.1.1. Холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журамд заасны дагуу мэдээлэх, тайлагнах мэдээлэл нь ил тод, нээлттэй байх;
 - 2.1.2. Мэдээлэл бодитой, үнэн зөв байх;
 - 2.1.3. Мэдээллийг заасан цаг хугацаанд нь тайлагнах, шинэчлэх.

Гурав. Санхүүгийн болон санхүүгийн бус мэдээлэл

- 3.1. Компани холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журамд заасны дагуу дараах санхүүгийн болон санхүүгийн бус мэдээллүүдийг олон нийтэд мэдээлнэ:
 - 3.1.1. Компанийн даатгал, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журамд заасны дагуу мэдээлэх, тайлагнах үүрэг бүхий үндсэн мэдээлэл;
 - 3.1.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хуралдаанд оролцсон ирцийн талаар;
 - 3.1.3. Аудитын бодлого, Аудитын хорооны бүрэлдэхүүн, үйл ажиллагааны журам, хурлын давтамж, ирцийн талаар;
 - 3.1.4. Цалин, урамшууллын бодлого, Цалин, урамшууллын хорооны бүрэлдэхүүн, үйл ажиллагааны журам, хурлын давтамж, ирцийн талаар;
 - 3.1.5. Залгамж халааны бодлого, Нэр дэвшүүлэх хорооны үйл ажиллагааны журам, хурлын давтамж, ирцийн талаар;
 - 3.1.6. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийн талаар;

- 3.1.7. Эрсдэлийн удирдлагын тогтолцоо, журам, хэргжилтийн талаар;
 - 3.1.8. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэх, эрсдэлийг хэрхэн удирдаж буй талаар;
 - 3.1.9. Компанийн ёс зүйн дүрэм;
- 3.2. Мэдээллийг хариуцсан ажилтан дараах сувгуудаар олон нийтэд хүргэнэ:
- 3.2.1. Хууль, тогтоомж, дүрэм, журамд заасны дагуу төвийн өдөр тутмын сонин, хэвлэлээр;
 - 3.2.2. Компанийн цахим хуудсаар.
- 3.3. Мэдээлэх, тайлагнах хугацаа:
- 3.3.1. Хууль, тогтоомж, дүрэм, журамд тусгайлан заасан хугацаанд;
 - 3.3.2. Даатгал, санхүүгийн үйл ажиллагааны жилийн эцсийн тайлангийн хугацаанд;
 - 3.3.3. Мэдээллийн шинэчлэл, өөрчлөлтийг тухай бүр.



“Ган зам даатгал” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн хурлын 09 дүгээр Тогтоолын 09 дүгээр хавсралт

“Ган зам даатгал” ХХК-ийн Эрсдэлийн
удирдлагын заавар

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Компанийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлж, хэрэгжүүлэхэд энэхүү зааврыг удирдлага болгоно.

Хоёр. Эрсдэлийн удирдлага

- 2.1. Төлөөлөн удирдах зөвлөл/ТҮЗ/ нь компанийн үйл ажиллагааны бүхий л чиглэлийг эрсдэлийн удирдлагаар хангаж, дотооддоо мөрдөх эрсдэлийн удирдлагын зааврыг компанийн бизнесийн цар хүрээ, үйл ажиллагааны онцлог, бүтэц, зохион байгуулалтад нийцүүлэн батална.
- 2.2. Компанийн үйл ажиллагааны цар хүрээ, бүтэцтэй уялдуулан эрсдэлийн удирдлагын асуудлыг ТҮЗ-ийн дэргэдэх Аудитын хороонд давхар хариуцуулах бөгөөд тус Хороо компанийн эрсдэлийн удирдлага, түүний хэрэгжилтэд хяналт тавина.

Гурав. Эрсдэлийг үнэлж, тодорхойлох, авах
хариу арга хэмжээ

- 3.1. Компанийн даатгалын үйл ажиллагаанд ирээдүйд тохиолдох магадлал бүхий, учирч болох эрсдэлийг үнэлж, дараах төрөлд ангилна:
 - 3.1.1. Гэрээний эрсдэл;
 - 3.1.2. Зах зээлийн эрсдэл;
 - 3.1.3. Санхүүгийн эрсдэл;
 - 3.1.4. Хууль, эрх зүйн эрсдэл;
 - 3.1.5. Техник, технологийн эрсдэл;
 - 3.1.6. Хүний хүчин зүйлийн эрсдэл.
- 3.2. Эрсдэлийг бууруулах хариу арга хэмжээг дараах байдлаар тодорхойлно:
 - 3.2.1. Гэрээний эрсдэлийн хувьд:
 - гэрээний эрх зүйн үндсийг сайтар боловсруулах;
 - гэрээний сахилга батыг чанд сахих;

- гэрээ цуцлах болон гэрээ биелүүлээгүй тохиолдолд гарах үр дагавар, түүнийг арилгах талаар урьдчилан тооцож, гэрээнд тусгах.

3.2.2. Зах зээлийн эрсдэлийн хувьд:

- зах зээлийн өндөр мэдрэмж, судалгаа;
- реклам, сурдалчилгааны ажлын чанар, хамрах хүрээ;
- даатгалын үнэлгээ, хураамжийн уян хатан бодлого;
- актуар тооцоолол, андеррайтингийн тооцооллын тоон мэдээллийн шинэчлэлт.

3.2.3. Санхүүгийн эрсдэлийн хувьд:

- дүрмийн сан болон нөөц санг байршуулах банк, банк бус санхүүгийн байгууллага, үнэт цаасны судалгаа;
- банк, санхүү, мөнгөний бодлогын үнэн бодит мэдээлэл, чиг хандлагын тодорхойлолт;
- төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийн зохистой харьцааг хангах ажиллагаа.

3.2.4. Хууль, эрх зүйн эрсдэлийн хувьд:

- хууль сурталчлах, хэрэгжүүлэх, сахин биелүүлэх үйл ажиллагаа;
- даатгалын хууль тогтоомж, зохицуулах байгууллагаас гаргасан багц дүрэм, журам, тэдгээрт оруулсан нэмэлт, өөрчлөлт, шинэчлэлийн хэрэгжилт;
- ажилтнуудын хууль, эрх зүйн мэдлэг.

3.2.5. Техник, технологи, тоног төхөөрөмжийн эрсдэлийн хувьд:

- шаардлагатай техник, тоног төхөөрөмжийн хангарт, шинэчлэлт;
- даатгалын бүтээгдэхүүний мэдээллийн сангийн бүрдүүлэлт;
- техник, тоног төхөөрөмжийн хувьд бусдаас хараат бус байх;
- дижитал аюулгүй байдлын хангарт.

3.2.6. Хүний хүчин зүйлийн эрсдэлийн хувьд:

- Ажилтны ажлын хариуцлагын шаардлага хангарт;
- Ажилтны боловсрол, мэдлэг, туршлага, үр чадвар, идэвхи, зүтгэл;
- Ажилтны харьцааны соёл, ёс зүй.

Дөрөв. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- 4.1. Гүйцэтгэх захирал “Эрсдэлийн удирдлагын заавар”-ын хүрээнд эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэнэ.
- 4.2. Компанид тулгарч буй эрсдэл, түүнийг хэрхэн удирдаж буй талаарх мэдээллийг гүйцэтгэх захирал Аудитын хороонд өгч, заавар, удирдамж авна.

- 4.3. Аудитын хороо шаардлагатай тохиолдолд учирсан эрсдэлд үнэлэлт, дүгнэлт өгч, холбогдох зөвлөмжийг ТУЗ-д танилцуулж шийдвэрлүүлнэ.
- 4.4. Аудитын хороо компанийн эрсдэлийн удирдлагын тогтолцоо, журам, хэрэгжилтийн талаар жилийн үйл ажиллагааны тайлан, цахим хуудсаар нийтэд мэдээлнэ.

-00o-



“Ган зам даатгал” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн хурлын 09 дүгээр Тогтоолын 10 дугаар хавсралт

“Ган зам даатгал” ХХК-ийн Комплайнсын хяналтын заавар

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү заавар нь компани эрсдэлийн удирдлагын хөтөлбөр, дүрэм, журмыг хэрэгжүүлэн компанийн засаглалыг сайжруулахад комплайнсын соёлыг бурдүүлэх, төлөвшүүлэх, хяналтыг хэрэгжүүлэх арга хэлбэрийг тодорхойлоход чиглэгдэнэ.

Хоёр. Комплайнсын хяналтын үндсэн зарчим

- 2.1. Хараат бус, бие даасан байх;
- 2.2. Ил тод, нээлттэй байх;
- 2.3. Сонирхлын зөрчлөөс ангид байх.

Гурав. Комплайнсын хяналтыг хэрэгжүүлэх чиг үүрэг

- 3.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн чиг үүрэг:
 - 3.1.1. Бодлогын баримт бичиг, дотоод дүрэм, журам, зааврыг батлах;
 - 3.1.2. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр компанийн эрсдэлийн төвшин, онцлогт нийцсэн дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөрийг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавих;
 - 3.1.3. Комплайнсыг хэрэгжүүлэхэд шаардлагатай бол зардал баталж өгөх;
 - 3.1.4. Комплайнсын хэрэгжилтийн тайлан мэдээг хүлээн авч, танилцах.
- 3.2. Гүйцэтгэх удирдлагын чиг үүрэг:
 - 3.2.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн баталсан комплайнсын хөтөлбөр, хяналтын зааврыг хэрэгжүүлэх;
 - 3.2.2. Комплайнсын хяналтын зааврыг хэрэгжүүлэх хүрээнд өдөр тутмын үйл ажиллагааг удирдлагаар хангаж, чиглүүлэх;
 - 3.2.3. Компанийн эрсдэлийг олж илрүүлэх, удирдах, хянах үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

3.3. Компанийн ажилтны чиг үүрэг:

- 3.3.1. Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, комплайнсын хөтөлбөр, зааврыг үйл ажиллагаандaa мөрдөх;
- 3.3.2. Мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөх;
- 3.3.3. Комплайнсын хяналт шалгалтад шаардлагатай туслалцаа үзүүлж, хамтран ажиллах.
- 3.4. Компанийн үйл ажиллагааны цар хүрээ, бүтэц, онцлогт нийцүүлэн комплайнсын ажил үүргийг аль нэг ажилтанд хариуцуулах бөгөөд түүний чиг үүрэг нь:
 - 3.4.1. Хууль тогтоомж, компанийн холбогдох дүрэм, журам, зааврын хэрэгжилтийг хянах, хангуулах;
 - 3.4.2. Компанийн онцлогт тохирсон хөтөлбөр, бодлогын баримт бичиг, дотоод дүрэм, журам, заавар боловсруулах;
 - 3.4.3. Компанид комплайнсын соёлыг бүрдүүлэх, төлөвшүүлэх;
 - 3.4.4. Компанийн ажилтан, удирдлагад зориулсан сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх;
 - 3.4.5. Зохицуулагч болон гадны байгууллагатай харилцаадаа комплайнсын чиглэлээр байгууллагыг төлөөлөх, зохицуулагч байгууллагаас шаардсан мэдээллийг цаг хугацаанд нь гаргаж өгөх;
 - 3.4.6. Зөрчлийн талаар мэдээлэх "шүгэл үлээх" ажиллагааг хэрэгжүүлэх, шүгэл үлээгчийн мэдээллийг хүлээн авч, удирдлагад мэдэгдэж, холбогдох арга хэмжээг авч ажиллах;
 - 3.4.7. Мэдээллийг бичгээр эсвэл цахим шуудан, утсаар хүлээн авна;
 - 3.4.8. Зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч, хянах явцад мэдээлэгчийн нууцлалыг чандлан хадгална;
 - 3.4.9. Комплайнсын хэрэгжилтийн талаар удирдлагад мэдээлж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал, зөвлөмж гаргах.
- 3.5. Компанийн эрх бүхий албан тушаалтан, ажилтан ёс зүйн дүрэм зөрчих, ашиг сонирхлын зөрчил үүсэх, албан тушаалын болон авлига хээл хахуультай холбоотой аливаа хууль бус үйлдэлд шүгэл үлээгч байна.